

НИЙГМИЙН ЦАГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

С.Гомбо

Философийн ухааны доктор (Ph.D), профессор

Нийгмийн цагийн ашиглалтыг судалсан эрдэмтэд түүхийн цаг гэдэг ойлголтын дор хүн төрөлхтний амьдралын үргэлжлэх хугацааг түүний ашиглалтын социаль асудлыг авч үзэж судалсаар иржээ. Тэгэхдээ энэ түүхэн цагийг тодорхой модификаци хийхдээ нийгмийн субъектын оршин амьдрах тодорхой үе шаттай нягт холбоотой тайлбарладаг. Жишээлбэл, календарийн нийт үргэлжлэх хугацаанаас долоо хоног, сар, жилээр хэсэглэн авч судалсан баримт элбэг бий. Нийгмийн цагийн нэг тодорхой хэсгийнх нөгөөхөөсөө хэрхэн юунаас болж өөрчлөгдөв гэдэгт л анхаарлаа тавьж судалсан байдаг. Ийм өөрчлөлт гарахын уг үндэс нь нийгмийн хөдөлмөр зохион байгуулалт, нийгмийн гишүүн бүрийн ажил амьдралаа жолоодох арга ухаантай шууд холбоотой гэж үздэг.

Хоногийн 24 цаг, долоо хоногийн 168 цаг, хугацааны хувьд хүн бүрт ижилхэн ноогдох боловч эзэмшигчид энэ хугацааг янз бүрээр ашигладаг. Эндээс л нийгмийн цаг /социальное время/-ийн тухай ойлголт гардаг. Аливаа нийгмийн бүлэг, хамт олны, хувь хүний хөгжил дэвшил нийгмийн цагийг хэмнэж, нэгж хугацааг үр ашигтай ашиглах зарчмыг хэрхэн хэрэгжүүлэх аргачлал технологи соёлоос хамааралтайг судлаачид онцлон тэмдэглэдэг юм.

Нийгмийн цаг нь хувь хүнээс эхлээд нийгмийн байгууллыг бүхэлд нь хамаарч "нийгмийн бүх системийн нийлбэр"¹ болохын хувьд тухайн нийгмийн хөгжин өөрчлөгдөх, оршин тогтнох цаг хугацаа юм гэж социологич В.А.Артемов тодорхойлжээ.²

Ийм учраас энэ хугацаа бол нийгмийн ахуйн өөрөөр хэлбэл, тэдний материаллаг үйл ажиллагаа энэ явцад тэдний хооронд үүсдэг бүхий л харилцааг тусгаж байдаг юм.

Нийгмийн цаг нь нийгэмд болж буй үзэгдэл үй явц, тэдгээрийн үр дүнгүүдийн үргэлжлэл, залгамж холбоо, дэс дарааллын нэгдлээр илэрхийлэгддэг. Товчоор хэлбэл нийгмийн цаг бол хүмүүсийн үйл ажиллагаатай шууд холбоотой цаг хугацаа юм. Гэвч В.И.Вернадский "амьдралын үзэгдэл үйл явцтай холбогдох цаг" гэж нэрлэсэн байдаг. Энд "холбогдох" гэдэг үг нийгмийн цагийн тухай ойлголтыг тодорхойлоход чухал үүрэгтэй. Жишээлбэл үйлдвэрийн машины ажиллаж байгаа цаг нийгмийн цагт орох уу? Машин ажиллаж байгаа болохоос хүний шууд үйл ажиллагаа биш учраас ормооргүй мэт. Нөгөө талаар бол хүн цагаа нэмэгдүүлж өөрийн хэрэгцээгээ бүрэн дүүрэн хангах зорилгоор хүмүүс тусгайлан бүтээсэн машинаар ажлаа гүйцэтгэж байгаа учраас нийгмийн цагт хамруулан үзэх ёстой юм. Хүн хэдий чинээ боловсронгуй машин бүтээнэв төдий чинээ нийгмийн цагийг үр ашигтай зарцуулдаг билээ.


Нийгмийн цагийн онцлог нь хоорондоо ямар ч холбоогүй тус тусдаа буй хүмүүсийн амьдралаас биш түүнийг бүрдүүлж байгаа харилцан үйлчлэлийн үр дүн гэж ойлгох ёстой юм. Ийм учраас энэ нь нийгмийн янз бүрийн бүлгүүдийн болон нийгмийн бүх гишүүдийн үйл ажиллагааны цагийн нийлбэр нэгдлээс бүрддэг. Нийгмийн цаг нь нийгмийн дурын субъектын нөөц баялаг гэж үзэж болно. Гэхдээ нийгмийн цаг нь нийгмийн хөгжлийн бодит хуулиудтай юуны өмнө эдийн засгийн хуультай тохирч байдаг. Ингэхийн тулд тэр хуулиудын тухай мэдлэг түүн дээр үндэслэгдсэн нийгмийн бүлгүүдийн, хүн бүрийн ухамсартай үйл ажиллагаа чухал байдаг. Ийм учраас манай нийгмийн гишүүн хүн бүрийн цаг ашиглалтын нийлбэрээр монголчууд бидний нийгмийн цаг ашиглалтын түвшин тодорхойлогдох ёстой. Энэ нь бид бүхний социаль харилцааны түвшинг нэгэн адил илэрхийлж байдаг байна. Аль нэгэн улс орны хөдөлмөрчдийн цаг ашиглалтын үр өгөөж нь ажлын цаг, чөлөөт цагийн хоорондын диалектик холбоог хэр зэрэг уялдуулж байгаагаас ихээхэн шалтгаалдаг. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл хүн чөлөөт цагаа ухамсартайгаар, зохион байгуулалттай ашиглах нь уг хүний боловсрол мэдлэгийн цар хүрээтэй холбоотой байдаг боловч эцсийн дүндээ ажил хөдөлмөрөө гүйцэтгэж байх явцдаа надад ийм зүйлийг шинээр сурч мэдэх хэрэгтэй юм байна

1 В.Г.Афанасьев. Научно-техническая революция, управление, образование. 432-р тал

2 В.А.Артемов. Социальное время. Проблемы изучения и использования. Новосибирск. 1987

гэдэг хэрэгцээ шаардлагыг ухаарсны үндсэн дээр чөлөөт цагаа зорилго чиглэлтэй ашиглах болдог гэсэн үг юм. Өөртөө дутагдаж байгаа тэр мэдлэг чадварыг хүн чөлөөт цагаараа олж авч байдаг учраас ажлын цагийн үр бүтээл нь улам нэмэгдэх болдог. Энэ утгаар К.Маркс чөлөөт цаг бол нийгмийн баялаг гэж үзэж байсан юм.

Хүн амын цаг ашиглалтын хэлбэрүүд, тэдгээрийн харилцан хамаарлын схем.



Тайлбар:

- - хүчин зүйлүүдийн нөлөөлөл
- ⇒ - цагийн хуваарилалт
- - цагийн хуваарилалтанд нөлөөлөх хүчин зүйлүүд
- ▭ - үйл ажиллагааны төрөл, хэлбэрүүд.

Энэ хорвоогийн аль ч улс орны хөгжил цэцэглэлт ба уналт нийгмийн баялаг болох чөлөөт цагийг оюуны авъяас чадвараа нэмэгдүүлэхийн төлөө хэр зэрэг ашиглаж ирсэнтэй шууд холбоотой байдаг. Гэтэл монголчууд цагийн үнэ цэнийг төдийлөн ойшоож үздэггүйгээс чөлөөт цагийн ашиглалтын соёл тун доогуур нам түвшинд байна. Энэ байдал 1980-иад оны эхэн буюу 1990 оны сүүлчээр хийгдсэн социологийн судалгааны баримтаас үзэхэд тодорхой байгаа юм. Тухайлбал, оюун ухааны нөөц боломжийг нэмэгдүүлэхийн төлөө зарцуулж байгаа хугацааг бусад орнуудад хийгдсэн судалгаатай харьцуулахад бараг 10 дахин бага байна. Эдүгээ XXI зуун руу алхлаа. Ирээдүйн хувь заяаг дэнслэх залуучууд маань чөлөөт цагаа ихэнх тохиолдолд юунд зарцуулж байгаа билээ. Ажиглалтаас үзэхэд арилжаа наймаа хийж олсон хэд гурвыгаа баар цэнгээний газар зугаа цэнгэлд л зарцуулдаг нь бараг хэвийн үзэгдэл боллоо. Алт мөнгөнөөс үнэтэй цаг хугацаагаа зугаа цэнгэлд зориулсаар байхуу?

Хүн төрөлхтөнд эрдэм ухааныг хайрласан эрдэмтэн мэргэд зав чөлөөтэй цагаа найр наадам зугаа цэнгэлд биш ирээдүйнхээ өөрийнхөө үеийнхнээс илүү ухаалаг амьдруулахын тулд ухааны ертөнцийг уужруулсаар /тэлсээр/ иржээ. Бидний ирээдүй-охид, хөвгүүд залуучууд маань эрдэм мэдлэг эзэмшиж ухаалгаар амьдрах чадвартай болоход зориулах ёстой нийгмийн баялаг болсон ихэнх цагаа баар цэнгээний газар өнгөрүүлэх ёсгүйсэн. Аав ээжийнхээ болон өөрсдөө арай ядан олсон хэд гурвыгаа нөгөө л "ид шидтэй" архи дарс, "найрка"-нд зориулж агсам согтуу тавьж алмайрч явмааргүйсэн. Өдгөө залуучуудын маань хэдэн хувь нь олигтой ажил эрхлэж амьдралын байр сууриа эзэлсэн билээ! Ихэнх нь ажилгүй л яваа. Юмхнаар юм хийж ажил амьдралаа дээшлэхгүй байгаагийн шалтгааныг өөрсдөөсөө биш өрөөлөөс нөгөө сонгуульд ялсан аль нэг нам эвслийнхнээс болж байгаа мэтээр хавтгайдаа дуу дуугаа авч шүүмжилцгээнэ. Энэ бүхэн бидний сэтгэлгээний өнөөгийн дүр төрх байх ёсгүй.

Дэлгэр сайхан цагт дуу дуугаа авалцан элдэв ой тэмдэглэх найр наадам бараг тасралтгүй үргэлжилнэ. Тэр нь одоо хөхөө өвлийн цагт ч нэмэгдэх хандлагтай. Ийм учраас түмэн олны минь төр засаг, төрийн болон үйлдвэрлэл үйлчилгээний бүх шатанд ард олныхоо ахуй амьдралыг, өөрсдийн нь нөөц чадавхыг шахан дайчлах замаар ажил үйлсийг нь өөд татахад онцгой анхаарах цаг аль хэдийнээ болсон.

Аль ч шатны удирдлага, менежерүүд бие хүний нийгмийн цагийн ашиглалтын хүчин зүйлүүд тэдгээрийн хоорондын холбоо хамаарлыг сайтар мэддэдэг байх ёстой. /Схем 1-г үзнэ үү/. Уг схемээр нийгмийн цагийн хүчин зүйлүүд, тэдгээрийн харилцан бие биедээ нөлөөлөх холбоо хамаарлыг загварчлан үзүүлээ.

Хувь хүний цагийн төсвийн үндсэн дээр тухайн хамт олны цаг ашиглалтын нийлбэр фондыг тооцоолж нийгмийн цагийн үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлага тулгамдсан асуудал болж байна. Аливаа зүйлийг гүйцэтгэхэд цаг хүрэлцэхгүй байна гэж харамсах хүн бишгүй дайралддаг. Бага хугацаанд ихийг бүтээдэг байхын тулд юуны өмнө хувийн зохион байгуулалт, сахилга бат нэн чухал юм.